



КОМПЛАЕНСЫН АЖИЛТНЫГ МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТ

Санхүүгийн салбарын МУТСТ үйл
ажиллагаа хариуцсан КОМПЛАЕНСЫН
АЖИЛТНУУДАД ЗОРИУЛАВ.

Санхүүгийн боловсролын HUB



**МҮЭ-ИЙН МУТСТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН
КОМПАЕНСЫН АЖИЛТНЫГ МЭРГЭШҮҮЛЭХ
СЕРТИФИКАТ ОЛГОХ
ПРАКТИКТ СУУРИЛСАН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

Сургалтын зорилго

ФАТФ-ын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) олон улсын стандартын хүрээнд улс орнууд МУТСТ хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналтын тогтолцоог сайжруулах үүргийн дагуу Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-оос түүний зохицуулалттай мэдээлэх үүрэгтэй этгээд (МҮЭ) тус бүр МУТСТ үйл ажиллагааг хариуцсан компаенсын ажилтныг томилон ажиллуулах журмыг хэрэгжүүлээд багагүй хугацаа өнгөрч байна. МҮЭ-үүд нь чиг үүрэг, ажлын цар хүрээнийхээ хүрээнд эрсдэлээ бүрэн ойлгож, олон улсын зөвлөмжүүд, тэдгээрийг хэрэгжүүлэх зорилгоор зохицуулагч байгууллагаас шаардаж буй хууль журам, дүрмийг чанд сахиулан биелүүлэх тал дээр МУТСТ үйл ажиллагааг хэрэгжүүлэх компаенсын ажилтнууд илүү нарийн мэргэшэх шаардлагатай байгаа нь СЗХ-ны хяналт шалгалт зохицуулалтын газраас гаргасан сургалтын хэрэгцээ, шаардлагаас харагдаж байна. Иймд бид МУТСТ үйл ажиллагаа хариуцсан ажилтнуудыг нарийн мэргэшүүлэх хэрэгцээ шаардлагад тулгуурлан МУТСТ болон компаенсын бусад эрсдэлээс урьдчилан сэргийлэх урьдач нөхцлийг бүрдүүлэх зорилгоор энэхүү сургалтыг зохион байгуулж, системтэй, мэргэшүүлэх мэдлэг олгож, улмаар мэдлэг бататгах тест шалгалтыг авч, сертификат олгох юм. 2025 онд СЗХ, Хамтын ажиллагааны зөвлөлтэй хамтран зохицуулалтын бүхий л салбарыг хамруулан Үндэсний эрсдэлийн үнэлгээ хийх тул компаенсын ажилтны хувьд мэргэшэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Зорилтот бүлэг

МУТСТ тухай хуулийн 4.1.-д заасан Мэдээлэх үүрэгтэй этгээдүүдийн МУТСТ үйл ажиллагаа хариуцсан компаенсын ажилтнууд болон хууль эрх зүй, дотоод хяналт хариуцсан ажилтнууд хамрагдана.


Сургалтын арга хэлбэр

Сургалт нь Санхүүгийн боловсролын HUB-ын МУТСТ чиглэлээр олон улсын болон дотоодын сертификаттай, туршлагатай зөвлөх, сургагч багш нарын чадавхи дээр суурилан дотоодын хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн хэрэгжилт, олон улсын практик, тэргүүн туршлагаас суралцах, бодит кейс дээр ажиллах, харилцан ярилцах байдлаар цахимаар Zoom meeting платформ дээр явагдах бөгөөд Бататгал хэлэлцүүлэг нь танхимд сургалтын 5 дахь өдөр явагдана.

Сургалтын онцлог

СЗХ-ны сургалтын журмын 2.3.7 болон 2.4.2 дахь заалтын дагуу Компаенсын ажилтан заавал сургалтад сууж сертификат авсан байхыг шаардаж байгаа юм. Түүнчлэн ФАТФ олон улсын байгууллагаас 2027 онд Монгол улсын 40 зөвлөмжийн хэрэгжилтийг газар дээр нь шалгахдаа 2023 оноос хойш хийж хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл дээр шалгалт хийх юм.

Сургалтын эцэст бататгал хэлэлцүүлэг СЗХ-ны санхүүгийн хүртээмжийн танхимд хийнэ. Хэлэлцүүлэгт СЗХ, СМА болон хууль сахиулах байгууллага, мэргэжлийн байгууллагуудын төлөөлөл оролцоно.



Сургалтад оролцсон оролцогч сургалтын эцэст танхимд шалгалт өгч, 70 хувиас дээш оноогоор тэнцсэн тохиолдолд СЗХороотой хамтарсан Мэргэшүүлэх сургалтын сертификат олгоно.

Сургалтад тавигдах шаардлага

Комплаенсын анхан шатны сургалтад заавал хамрагдсан байх.

Сургагч багш нар

Э.Тамир /СЭЗИС-ийн багш, Доктор/
А.Уянга /СЗХ-ны ХШЗГ-ын МУТА, ахлах мэргэжилтэн/
Г.Даваахүү /МБ, СМА, БЗХАХэлтсийн захирал/
С.Ариунтуяа /СМА, ахлах мэргэжилтэн/
З.Эрдэм /Монголын COMPLAEN-ын Холбооны Гүйцэтгэх захирал/
Ч.Зоригтбаатар /Хуульч, өмгөөлөгч/
З.Оюунчимэг /Мэргэшсэн КА, Төрийн банк/
П.Орхон /Мэргэшсэн КА, Ахлах, Хаанбанк/
Б.Нямжаргал /Сэндли ББСБ, Үйл ажиллагаа хариуцсан захирал/
Т.Баасанбат /Хаан банк, КХА/
Н.Энхмандах /ЭЦГ, Цагдаагийн ахмад/
Т.Чинзоригт /ТТЗ-ийн тасгийн дарга/

Сургалтын огноо

2025 оны 06-р сарын 09-13-ны өдрүүдэд 09:30-13:00 цаг хооронд

Анхаарах зүйл

Сургалт эхлэхээс 15 минутын өмнө холбогдсон байх бөгөөд камерыг сургалтын турш нээлттэй байлгана.

Сургалтын 5 дахь өдөр Бататгал хэлэлцүүлэг СЗХ-ны Санхүүгийн хүртээмжийн танхимд болно.

ДЭЛГЭРЭНГҮЙ ХӨТӨЛБӨР

ЭХНИЙ ӨДӨР /06 САРЫН 09/

Цаг	Сэдэв	Агуулга	Сургагч багш
09:30-10:30	Комплаенсын тухай ойлголт, түүний эрсдэл	- Комплаенсын үүсэл хөгжил, - Комплаенсын эрсдэл	Э.Тамир СЭЗИС-ийн багш
10:30-11:30	Салбарын мэдээлэл, МУТС эрсдэлийн үнэлгээ	- Салбарын өнөөгийн нөхцөл байдал, - Үндэсний эрсдэлийн үнэлгээ	А.Уянга СЗХ-ны МУТА Ахлах мэргэжилтэн
11:30-11:40	Цайны завсарлага		
11:40-12:40	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй	- Монгол улсын МУТС тухай хууль - МУТС үндэсний зөвлөл - Хамтын ажиллагааны зөвлөл	Г.Даваахүү МБ, СМА, БЗХАХ-ийн захирал

	тэмцэх Монгол улсын тогтолцоо	Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа	
--	-------------------------------	---	--

ХОЁР ДАХЬ ӨДӨР /06 САРЫН 10/

Цаг	Сэдэв	Агуулга	Сургагч багш
09:30-10:30	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт	ОУ-ын стандарт шаардлага, - ФАТФ-ын 40 зөвлөмж, - Базелийн хорооны стандарт, - Европын холбооны шийдвэр, - Вольфсберг болон Эгмонт группийн танилцуулга, - Дэлхийн банк, - АНУ-ын OFAC болон FinCEN шаардлага	З.Эрдэм Монголын Комплаенсын Холбооны Гүйцэтгэх захирал
10:30-11:30	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн тухай ойлголт	- МУТС гэмт хэргийн тодорхойлолт, үе шат, - МУТС гэмт хэргийн нийгэм эдийн засагт учруулах сөрөг үр дагавар – Кейс дасгал ажил	Ч. Зоригтбаатар Хуульч, өмгөөлөгч
11:30-11:40	Цайны завсарлага		
11:40-12:40	Хориг арга хэмжээний хяналт, түүнийг хэрэгжүүлэх тухай	- НҮБ болон бусад олон улсын хориг арга хэмжээний тухай ойлголт - Хоригтой тулгах үйл ажиллагаа, - Хориг арга хэмжээний хяналтыг хэрэгжүүлээгүйгээс үүсэх үр дагавар	Чинзоригт ТТЗөвлөлийн тасгийн дарга

ГУРАВ ДАХЬ ӨДӨР /06 САРЫН 11/

Цаг	Сэдэв	Агуулга	Сургагч багш
09:30-10:30	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн тухай ойлголт, хүчин зүйлс, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ	- МУТС эрсдэлийн тухай ойлголт, эрсдэлд суурилсан аргачлал - Эрсдэл үүсгэгч хүчин зүйл, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ - Эрсдэлийн үнэлгээний аргачлал	П.Орхон Мэргэшсэн КА, Ахлах, Хаанбанк

10:30-11:30	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөр	МУТС дотоод хяналтын хөтөлбөр - МУТСТ дотоод бодлого, журмын ерөнхий тогтолцоо МУТСТ үндсэн чиг үүрэг: - Харилцагчаа таньж мэдэх үйл ажиллагааны хөтөлбөр - Бүтээгдэхүүн үйлчилгээний хяналтын хөтөлбөр - Гүйлгээний тусгай хяналтын хөтөлбөр - Хориг арга хэмжээний хөтөлбөр, үндсэн тогтолцоо Сургалтын хөтөлбөр	З. Оюунчимэг, Мэргэшсэн КА, Төрийн банк
11:30-11:40	Цайны завсарлага		
11:40-12:40	Харилцагч таньж мэдэх үйл ажиллагаа	- Харилцагч таньж мэдэх нарийвчилсан болон хялбаршуулсан үйл ажиллагааны тухай ойлголт - Харилцагчийн төрөл тус бүрийг таньж мэдэх, хувийн хэргийн бүрдлийг хангах - Улс төрд нөлөө бүхий этгээдийг тодорхойлох, хяналт тавих ажиллагаа - Эцсийн өмчлөгч тогтоох журам, аргачлал	Т.Баасанбат Санхүүгийн боловсролын HUB, сургагч багш

ДӨРӨВ ДЭХ ӨДӨР /06 САРЫН 12/

Цаг	Сэдэв	Агуулга	Сургагч багш
09:30-10:30	Гүйлгээний тусгай хяналтыг хэрэгжүүлэх, сэжигтэй гүйлгээ / үйлдэл илрүүлэх үйл ажиллагаа	- Гүйлгээний тусгай хяналтын тогтолцоо, ерөнхий ойлголт, - Сэжигтэй гүйлгээний типологи, төрөл, түүнийг илрүүлэх аргачлал - Гүйлгээний хяналтын програм, хяналтын дүрэм үүсгэх - Сэжигтэй гүйлгээний алерт дээр ажиллах, дүн шинжилгээ хийх,	Б.Нямжаргал ОУ-ын Комплаенсын мэргэшсэн ажилтан

		- Сэжигтэй гүйлгээ/ үйлдэл илрүүлэх бусад эх сурвалж, - Сэжигтэй гүйлгээ, үйлдлийг мэдээлэх, шийдвэр гаргах үйл ажиллагаа	
10:30-11:30	Сэжигтэй үйлдэл/гүйлгээтэй холбоотой хууль хяналт болон зохицуулагч байгууллагатай харилцах нь	СМА-д мэдээлэл дамжуулах, солилцох, мэдээлэл гаргаж өгөх тогтолцоо GoAML програмын ашиглалт	С. Ариунтуяа СМА, Ахлах мэргэжилтэн /видео/
11:30-11:40	Цайны завсарлага		
11:40-12:40	Хууль хяналтын байгууллагын мөрдөн шалгах ажиллагаанд хамтран ажиллах	- СМА, хууль сахиулах байгууллагад мэдээ, мэдээлэл дамжуулахад анхаарах зүйлс - Дасгал ажил	Н.Энхмандах ЭЦГ-ын ГХТТ, цагдаагийн ахмад

ТАВ ДАХЬ ӨДӨР /04 САРЫН 13/

Цаг	Сэдэв	Агуулга	Сургагч багш
10:00-10:15 10:15-11:15	Мэдлэг бататгах хэлэлцүүлэг, семинар /танхимаар/	- МУТСТ үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой комплаенсын ажилтны үүрэг оролцоо - Дасгал ажил, кэйс хэлэлцүүлэг - Асуулт хариулт	Сургагч багш нар удирдан явуулна.
11:15-11:30	Цайны завсарлага		
11:30-12:30	Шалгалт	Цахимаар авах	Сургалтын менежер Санхүүгийн боловсролын HUB, сургагч багш